

Гэр бүл - XXI зуун

Доктор /С./, профессор Т.Намжил
/ Улаанбаатар дээд сургууль/

Монгол гэр бүл судлалыг анхаарч, хөгжүүлэхийн хамтад дэлхийн улс орнуудын гэр бүлийн судалгааны дүнд гарч ирж байгаа санал, дүгнэлтэд бид анхааралтай, нухацтэй хандах цаг болоод байна.

Нийгэмд гарч ирчихээд сөргөөр нөлөөлж буй үзэгдлийн эсрэг тэмцэхийн зэрэгцээ дэлхийн голлох оронд үүсчихсэн, манай оронд нөлөөлж болзошгүй асуудлыг урьтан харж, мэдэж баймаар байна.

Ойрын 5-15 жилд манай оронд гэр бүлийн, түүний дотор залуу гэр бүлийн асуудал улам нарийсч тавигдана.

Ийм таамаглал Монголын болоод Европ, Ази, Америкийн гэр бүлийн нийгмийн түүхийн хөгжлийг өнгөрсөн, одоо, ирээдүйн холбоонд нь үндэслэн үзэхээр гарч ирж байгаа юм.

Бидний судалгааны явцад Монголчуудын гэр бүлийн түүхэн уламжлал нь Азийн улмаар Европын орнуудынхтай харилцан нөлөөлөлтэй байсан нь харагддаг.

Тэгэхлээр биднээс өөрсдийн гэр бүлийн талаар явуулах бодлого, олон талт үйл ажиллагаа нь дэлхийн бусад орнуудынхтай ямар нэгэн хэмжээгээр холбогдож байх ёстой болж байна. Ер нь ч тийм зүй тогтолтой. Орчин үеийн гэр бүлийн талаархи аливаа асуудал нь тухайн нэг орны хүрээнд төдийгүй бүс нутаг, тив, улмаар дэлхий дахины асуудал болж байна. Тухайлбал:

. АНУ-д гэр бүлийн байдал ямар байгаа талаар санал асуулгыг 1978 онд америкчуудын дунд явуулахад: "Эрчүүд мөнгө олж, эмэгтэйчүүд гэртээ хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх нь нийгэмд хэрэгтэй" гэдэгтэй насанд хүрэгчдийн 66 хувь нь санал нийлж байгаагаа илэрхийлжээ. 1998 онд энэ үзүүлэлт 38 хувь хүртэл буурчээ.

. Буурай хөгжилтэй оронд ихэвчлэн эхнэр нь ар гэр, үр хүүхдээ харж хандан, нөхөр нь мөнгө олдог бол өнөөгийн Америкт өөр болох хандлагатай болжээ. Өнөөдөр Америкт ганцаараа хүүхдээ өсгөж буй эрчүүдийн тоо өссөөр байгаа бөгөөд сүүлийн үед эхнэр, нөхөр хоёрын хэн нь ажил, албандаа ахих ирээдүйтэй, илүү цалин авдагаа харьцуулж үзээд эхнэр нь ажиллаж, нөхөр нь хүүхдээ харж гэртээ байх нь илүүтэй болжээ.

. Европт энэ байдал эсрэгээр байна. Европ, Азийн зарим гол орнууд тухайлбал, Орос, Японд гэр бүл, гэрлэлтийн асуудлаар явуулсан социологийн болон тоо бүртгэлийн судалгааны дүнгээс үзүүлбэл: Японд гэрлэлтийн тоо 1960-1975 онд бараг хэвийн байсан бол 1980-аад оноос 10 гаруй хувиар буурч, 1997 он дуусталх хугацаанд өсөлт гарсангүй. Гэтэл гэр бүлийн салалт 1960 оныхоос 3 дахин нэмэгджээ. Ийнхүү орчин үеийн гэр бүлийн салалтын хувь өсч байгаа болон гэрлэгсдийн тоо буурч, ганц бие хүмүүсийн тоо олширч байгаа зэрэг нь хууль ёсны гэр бүлийн ач холбогдол алдагдаж байгааг харуулж байна.

Гэр бүлийн харилцаанд гарч ирж байгаа энэ чиг хандлагыг зохих ёсоор хүлээж, анхаарах ёстой. Олонхи хүмүүс гэр бүл, гэрлэлтийн уламжлалт хэлбэрийг даган амьдарч, харин залуучуудын дотор энэ нь алдагдан зөрчигдөх боллоо. Гэсэн хэдий ч гэрлэлтээ цуцлах болон сонголт хийх боломж бий болсоор байгаа нь уламжлалт гэр бүлд ч нөлөөлж байна. Үүний хамтад ихэнх хүмүүс өөрсдийн гэр бүлийн амьдралд улам илүү анхаарал, шаардлага тавих болж байна. Энэ нь ч аргагүй юм. Гэхдээ амьдралын уламжлалт болон шинэ хэлбэрүүд бие биенээсээ огт хамааралгүй биш байгааг санах ёстой.

Анхны гэрлэлтийн дундаж нас 1950 онд эрэгтэй нь 26, эмэгтэй 23 нас байсан бол 1995 онд эрэгтэй, эмэгтэйн гэрлэлтийн дундаж нас 4-өөс 3 насаар нэмэгдэж, эрэгтэй нь 30 нас, эмэгтэй нь 27 нас хүрэх болсон байна.

Ийнхүү гэр бүл болох дундаж нас нэмэгдэж байгаа нь зохих шалтгаантай болох нь харагдаж байгаа юм.

Залуу эмэгтэйчүүдийн хувьд гэвэл:

- Гэрлэхгүйгээр амьдарч чадна;
- Өөрсдөө гэр орноо авч явна;
- Сэтгэлдээ таарсан ханиа сонгож олоход хэцүү байдаг гэж байгаа бол;

Залуу эрчүүдийн хувьд:

- Гэрлэхгүйгээр сайхан амьдарч чадна;
- Гэрлэхэд эдийн засгийн хувьд илүү зардал гарна;
- Сэтгэлдээ таарсан ханиа сонгож олоход хэцүү гэх зэргээр үзэцгээдэг болж байна.

Гэхдээ залуу эрэгтэй, эмэгтэйн аль аль нь "Гэр бүлгүй байх нь удаан үргэлжлэхгүй" гэж боддог нь гэрлэлт зайлшгүй гэж үздэгтэй холбоотой.

Судалгаагаар анхаарал татаж байгаа өөр нэг асуудал бол 50 ба түүнээс доош насны хүмүүс, түүний дотор гэрлээгүй эрэгтэйчүүдийн тоо эмэгтэйчүүдийнхээс илүү өсөх хандлага бий болж байгаа явдал юм. Өмнө өгүүлсэн социологийн болон тоо бүртгэлийн үзүүлэлтүүд нь бидэнд зах зээлд хэдийнээ шилжиж хөгжлийн хувьд өндөр түвшинд хүрсэн орнууд дахь гэрлэлт, гэр бүлийн өнөөгийн байдал, түүний ямаршуу байгааг харуулж байна. Тухайлбал, гучаас дээш насанд гэрлэх, өөрөөр хэлбэл оройтож гэрлэх, гэрлэгсдийн тоо төдийлөн нэмэгдэхгүй, салалт өсөх хандлага үүсдэг байна.

"Лиза" сэтгүүлээс Европын голлох зарим орнуудын хүүхэдтэй гэр бүл болон нөхөргүй эхчүүдийн дунд "Гэр бүл тогтвортой байхад юу нөлөөлдөг вэ?" гэсэн асуудлаар явуулсан судалгааны дүнгээс үзэхэд уг судалгаанд оролцогсдын ихэнх нь "Гэр бүл бололцох үндэсний ёс заншил гэр бүлийг бат бэх байлгах хамгийн зөв арга" гэж тухайлбал, Герман, Орос, Унгар, Польшийн нөхөртэй эмэгтэйчүүдийн 82-98 хувь нь, эхнэртэй эрчүүдийн 80-89 хувь, ганц бие эхчүүдийн 64-81 хувь нь хариулцгаажээ.

Англи, Итали, Франц орнуудаас судалгаанд хамрагдагсдын 54-80 хүртэл хувь дээрхи хариулттай адил байна.

Европын орнуудын гэр бүлд үндэсний ёс заншлаа эрхэмлэн уламжилсаар байгаа болох нь харагдаж байгаа юм.

Харин судалгаанд хамрагдсан ганц бие эхчүүдээс Францын 31 хувь, Английн 42 хувь нь "Гэр бүл бололцох үндэсний ёс заншил гэр бүлийг бат бэх байлгах хамгийн зөв арга" гэжээ. Энэ нь анхаарал татах л асуудлын нэг.

Монголын хүн амын дунд ганц бие, өрх толгойлсон эх, эмэгтэйчүүд нийт өрхийн тодорхой хувийг эзэлж байгаа нөхцөлд дээрхи судалгааны дүн бидэнд нэгийг бодогдуулах нь лавтай. Тийм ч байх.

Бүгд Найрамдах Солонгос Улсад явуулсан нэгэн судалгаагаар "Та нөхөр, эхнэрээсээ юу хүсдэг вэ?" гэсэн асуултыг тавихад: Эрчүүдийн олонхи нь "Бидний эцэг, эхийг асрамжилах, өөрсдийгөө халамжлах, эрүүл мэндээ анхаарах"; Эхнэрүүд нь "Гэр бүлтэйгээ ихэнх цагаа өнгөрүүлж байгаачээ. Бидэнтэй илүү ярилцах цаг гаргаачээ"; зарим нь "Гэрийн ажилд туслаачээ" гэх зэргээр хариулсан байх юм.

"Албан ёсоор" гэр бүл болох хүсэл тэмүүлэл харьцангуйгаар бүүрч, салалтын тоо нэмэгдэж, төрөлтийн тоо төдийлөн өсөхгүй байгаа зэрэгтэй үялдан гэр бүлд ирээдүй гэж бий юу? - гэсэн асуулт зүй ёсоор гарч ирж байгаа юм.

Хүн ам зүйн аргаар статистикийн урьдчилсан мэдээг гаргаж болохгүй. Гэсэн хэдий ч ойрын жилүүдэд гэр бүл, гэрлэлтэд дор хаяж гурван өөрчлөлт гарч болох юм гэдгийг 20-р зууны туршид дэлхийн улс орнуудын гэр бүлийн амьдралд гарсан өөрчлөлт, гэр бүлийн нийгмийн түүхээр хийгдсэн судалгааны дүнд үндэслэн хэлж болно.

Нэгдүгээрт: Ихэнх хүмүүсийн хувьд сонголт хийж үр хүүхэдтэйгээ хамт хууль ёсны гэр бүл болохын зэрэгцээ тусдаа "гэр бүлийн" буюу "гэр бүлийн бус" шинж чанартай амьдралаар амьдрах боломжтой. Гэр бүл хамтран амьдрах жирийн хэлбэрийн монологи эрхээ алдана.

Хоёрдугаарт: Эцэг, эхийн гэр болон тусгаарлан өрх гэр болсон гэрт хүүхдээ төрүүлж, өсгөх хоёрын хооронд харьцангуй чөлөөт харилцааны хэлбэрийн завсарын "албан ёсны гэрлэлтийн баталгаа"-гүй хамтран амьдрах.

Аж үйлдвэр хөгжсөн нийгмийн хүмүүс өөрсдийн амьдралдаа урьдынхаасаа илүү ихээр амьдралынхаа загварыг өөрчлөх болно. Цөөвтөр тоотой хувь эзэлж буй хүмүүсийг эс оролцуулбал урт удаан хугацааны туршид харилцаатай хүмүүсийн харилцаан дахь үнэнч байх явдал хэвээр байна.

Эр, эмийн харилцаанд харилцан үнэнч байх явдал нь туйлын хүслэн байдаг. Ямар ч байлаа өөрийн хань нь өөр хүнтэй холбогдоход тэвчээртэй хандах явдал өсөх хандлагатай.

Гэрлэлтэд харилцан бие биенээ хайрлах, аз жаргалтай байх асуудалд тавих шаардлага өсч байгаа ч гэсэн гэр бүлийн хүмүүсийн эрх чөлөөт байдалд хүлээцтэй хандах явдал өсч байна.

Энэ нь нөгөө талаас гэрлэлт, гэр бүлийн цаашид оршин тогтноход аюул учруулж болох хандлага ихэсч байна гэсэн үг.

Хэрэв "гэр бүлээс гадуурхи холбоо" /нууц амрагийн холбоо/-г таслан зогсоохгүй бол гэр бүлийн салалт өсөх хандлага буурахгүй. Энэ нь гэрлэлт өөрийн онцлог шинжийг алдан чөлөөт, цаашид тасарч болох харилцааны шинж чанартай болно гэсэн үг.

Гуравдугаарт: Чөлөөт амьдралаар амьдарч буй хосууд болон ганц бие эмэгтэйчүүдийн хүмүүжүүлдэг хүүхдийн тоо цаашид өсөх хандлагатай байгаа явдал юм.

Хүн ам зүйн судлаачдын тодорхойлсноор сүүлийн жилүүдэд гарч байгаа салалт энэ чигтээ үргэлжилсээр байх юм бол ирээдүйд, жишээлбэл: Төв Европын хүн амын гурван хүн тутмын нэг нь амьдралынхаа эцэст ганцаараа үлдэх, дахин гэрлэсэн хүмүүсийн бараг гуравны нэг нь дахин салж, тэр салсан гэр бүлийн дөнгөж хоёрны нэг нь дахин гэрлэх бололцоотой болно.

Салалтын давтамж одоогийн түвшинд байгаа нөхцөлд 1980-аад оны эхний хагаст төрсөн 14 нас хүртэлх насны 8 хүүхэд дутмын нэг нь гэр бүл салалтын гэрч болох юм. Ингэснээр үр удмаа эрхэмлэх, хүүхдээс эцэг, эхдээ хандах хандлагын, асран халамжлах зарчмын утга улам алдагдаж байна.

Тэр тусмаа хүүхдийг үнэн сэтгэлээсээ хайрлах, хариуцах, хүүхэд нь настан буурлаа хүндэтгэн халамжлах, өрөвдөх сэтгэлгээ зөвхөн уламжлалт гэр бүлд л хамаатай болох төлөвтэй.

Цусан төрлийн харилцаанд үндэслэн эв нэгдэл, асран хамгаалах хэлбэр нь илүү их ач холбогдолтой болох магадлалтай байж болно.

Эдгээр хандлагын нийгмийн болон хүнд хамаарах үр дагаврын талаар маргаантай үзэл бодол байгаа.

Судалгаанаас үзэхэд хүүхэд, залуус болон ахмад хүмүүсийн хувьд гэр бүлийн уламжлалт хэлбэр цаашид алдагдах ба гэр бүл доторхи болон гадуурхи харилцан туслалцах шинэ хэлбэрүүдийг олох хэрэгтэй болно. Нөгөө талаас гэр бүл эв нэгдэлтэй байх, хүүхдэд хариуцлагатай байх ухамсар төлөвшүүлэх, ахмад хүмүүст тусалдаг, тэднийг халамжлах, тэдний төлөө хариуцлага хүлээх нь уламжлалт гэр бүлд амьдарч буй хүмүүст л зөвхөн хамаарна гэсэн ойлголт буруу юм.

ДҮГНЭЛТ

Төв Ази, Монголд эрт цагаас үндсэндээ нэгэн төрлийн аж ахуйг эрхэлж ирсэн нь хос гэр бүлийн зонхилсоор ирэхэд хүргэжээ. Энэхүү байдалд Европ, Америк орны гэр бүлийн бүтцэд гарч буй өөрчлөлт нөлөөлөх нь дамжиггүй.

Яагаад вэ? гэвэл Монгол орон дэлхийн хөгжилтэй орнуудын адил замд орж буй, тэдгээртэй харилцаагаа өргөжүүлж, хамтын ажиллагааг хөгжүүлж буй зэрэг хүчин зүйлтэй холбоотой.

Өнөөдөр дэлхий дахинаа гэр бүлийн асуудлаар эрдэм шинжилгээний болон нийтэд зориулагдсан ном зохиол, материалд бичигдээд байгаа "Уламжлалт гэр бүл"-ийн зэрэгцээ "Орчин үеийн гэр бүл"-ийн асуудал анхаарал татах боллоо.

Зарим судлаачид "орчин үеийн гэр бүл" гэсэн томъёоллоо эрт цагаас үүсч өнөөг хүрч ирсэн "эцгийн эрхт гэр бүл"-ийн эсрэг тавьж байна. Энэ нь угтаа нэг талаар "эхийн эрхт гэр бүл"-ийн асуудлыг анхаараад байгаа хэрэг юм.

"Орчин үеийн гэр бүл"-ийн асуудал өнөөдөр төдийгүй цаашид ч дэлхий дахинаа, түүний дотор бидний Монголчуудын өнөөгийн болон хойч үеийнхний анхаарах гол нэгэн асуудал байсаар байх ёстой болж байна.

"The family in the XXI century"

Summary

By T. Namjil.

The issue concerning the modern families has been becoming the central point of not only a single country but also the regions, continents and, moreover, the world. In the coming 5 to 15 years, family relations, especially of young families, will be addressed specifically.

From the ancient times people in the Central Asia and Mongolia have been engaged in a single way of life leading them to retain the dominant nuclear family form. However, the changes appeared in the family compositions in European countries and the United States are likely to affect the Mongolian way.

НОМ ЗҮЙ

1. Т.Намжил. Монгол, Өрнө, Дорно: Гэр бүлийн зан заншлын уламжлал, холбоо. УБ., 1999 он
2. Т.Намжил. Монгол ба Зүүн өмнөт Азийн гэр бүл. УБ. 2000 он.
3. Райнхард Зидер: Социальная история семьи в Западной и Центральной Европе. М., 1997.
4. KOREAN FAMILY AND KINSHIP. Seoul, 1997.